



ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар А/245

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Галт зэвсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.10 дахь хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1.“Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг нэгдүгээр, “Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдах төвд эрх олгох, салбар нээх болон төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар /тэргүүн комиссар Р.Чингис/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Үнэнбат/-т тус тус даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 157 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.ДОРЛИГЖАВ

ИРГЭНИЙ БОЛОН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ, ГАЛТ ЗЭВСЭГТЭЙ АДИЛТГАХ ХЭРЭГСЛИЙГ ИМПОРТЛОХ, НИЙТЭД ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрлийг Галт зэвсгийн тухай^[1] хуулийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр зөвхөн хуулийн этгээдэд олгоно.

1.3.Сонгон шалгаруулалтыг нээлттэй хэлбэрээр явуулна.

Хоёр.Сонгон шалгаруулалтын комисс

2.1.Галт зэвсгийн тухай хуулийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу хууль зүйн, спортын, байгаль орчны, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тагнуул, цагдаа, гаалийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн комисс /цаашид “Комисс” гэх/ сонгон шалгаруулалтыг эрхлэн гүйцэтгэнэ.

2.2.Комиссын бүрэлдэхүүн, үйл ажиллагааг Комиссын ажиллах журмаар зохицуулна.

Гурав. Сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлэх

3.1.Сонгон шалгаруулалтын зарыг өдөр тутмын хоёроос доошгүй сонинд нийтлүүлж, Хууль зүйн яамны вэб сайтад байршуулна.

3.2.Сонгон шалгаруулалтад оролцогчийн саналыг хүлээн авах эцсийн хугацаа нь өдөр тутмын сонин, байгууллагын вэб сайтад сонгон шалгаруулалтын зар нийтлэгдсэнээс хойш хуанлийн 30-аас доошгүй хоног байна.

3.3.Сонгон шалгаруулалтын зард дараах мэдээллийг тусгана:

3.3.1.Сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага;

3.3.2.Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг;

3.3.3. Сонгон шалгаруулалтын саналыг ирүүлэх, мэдээлэл авах хаяг;

3.3.4.Сонгон шалгаруулалтын санал хүлээн авах эцсийн хугацаа.

Дөрөв.Сонгон шалгаруулалтад оролцох хуулийн этгээдэд тавих шаардлага

4.1.Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хадгалах өөрийн өмчлөлийн агуулахтай байх;

4.1.2.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл тээвэрлэх тусгайлан тоногдсон буюу бүхээгтэй, цоожтой, аюултай ачааны таних тэмдэгтэй, галд тэсвэртэй материалаар тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй байх;

4.1.3.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг экспортлогч талын эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчийн тодорхойлолттой байх;

4.1.4.гадаадын хөрөнгө оруулалтгүй байх;

4.1.5.гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

4.1.6.хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй, гааль, татвар, нийгмийн даатгалын байгууллагад болон *шүүхийн шийдвэрийн дагуу иргэн, хуулийн этгээдэд төлөх өр төлбөргүй* байх;

4.1.7.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч болон гүйцэтгэх удирдлага нь ял шийтгүүлж байгаагүй байх;

4.1.8.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлтэй харьцаж ажиллах ажилтнууд нь Галт зэвсгийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан насанд хүрсэн, сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэн байх;

4.1.9.буудлагын спорт-сургалтын үйл ажиллагаа эрхэлдэггүй байх.

4.2.Энэ журмын 4.1.1-д заасан агуулах нь дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1.хамгаалалтын болон галын дохиоллын систем, гал унтраагч төхөөрөмж, хяналтын телекамераар тоноглогдсон байх;

4.2.2.харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хамгаалуулах;

4.2.3.телехяналтын систем нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн баталсан “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага”-ыг хангасан байх;

4.2.4.агуулахын хаалга нь төмөр, дотор тал нь галд шатдаггүй материалаар хийгдсэн, давхар хаалга, лацтай байх;

4.2.5.нарны гэрэл шууд тусахгүй, ус чийгнээс хамгаалагдсан, агааржуулалтын системтэй эсхүл салхивчтай байх. Салхивчтай бол дотор, гадна талаасаа төмөр хийцийн тороор хамгаалагдсан байна.

4.2.6.галт хэрэгслийн тавиур нь хананаас 40 см-ээс багагүй зайд шалнаас 20 см-ээс багагүй өндөрт байх;

4.2.7.аюулгүй байдлыг хангах дотоод журамтай байх.

Тав.Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг

5.1.Сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах материалыг бүрдүүлнэ:

5.1.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

5.1.2.хуулийн этгээдийн үүсгэн байгуулсанаас хойш явуулж буй үйл ажиллагааны болон үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлагын талаар дэлгэрэнгүй танилцуулга;

5.1.3.улсын хилээр оруулах, нийтэд худалдах галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн нэр, төрөл, марк, техникийн болон бусад үзүүлэлтийг заасан албан бичиг;

5.1.4.тухайн гадаад улсын худалдаж байгаа байгууллагын тодорхойлолт болон байгууллага, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй танилцуулга;

5.1.5.банк, татвар, гааль, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа, тодорхойлолт;

5.1.6.эрх бүхий аудитын байгууллагаар баталгаажсан сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан, баланс;

5.1.7.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хадгалах агуулахтайг нотлох баримт бичгийн хуулбар;

5.1.8.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгслийн холбогдох баримт бичгийн хуулбар;

5.1.9.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хадгалах агуулахын байршил, дотоод зохион байгуулалт, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн тавиур, сум хадгалах шүүгээ /сав/-ний нарийвчилсан зураг, танилцуулга;

5.1.10.ажилтнуудын танилцуулга, иргэний үнэмлэхний болон галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;

5.1.11.харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний төсөл.

Зургаа.Сонгон шалгаруулалтын баримт бичиг ирүүлэх, түүнийг хүлээн авах

6.1.Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь сонгон шалгаруулалтын баримт бичгийг товлосон хугацаанд, дурдсан хаягаар, хуудас тус бүрийг дугаарлан ирүүлнэ.

6.2.Оролцогч хуулийн этгээдийн нэр, хаяг, ирүүлсэн баримт бичгийн хуудасны тоо, огноо, цагийг Комиссын нарийн бичгийн дарга тэмдэглэж, хүлээн авах ба хүлээн авсан тухай тодорхойлолтыг оролцогчид өгнө.

6.3.Тогтоосон хугацаанаас хожимдсон, эсхүл дутуу бүрдүүлсэн материалыг хүлээж авахгүй.

6.4.Оролцогч нь сонгон шалгаруулалтын баримт бичгийг Комиссын гишүүдийн тоогоор хувилж өгнө.

Долоо.Сонгон шалгаруулалт явуулах

7.1.Комиссын гишүүд нь оролцогч тус бүр энэ журмын 4, 5-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, баримт бичгийг бүрэн гүйцэд зохих журмын дагуу бүрдүүлсэн эсэхийг хянан үзнэ.

7.2.Комиссын гишүүд сонгон шалгаруулалтын явцад оролцогчийн талаарх тодорхой мэдээлэлтэй газар дээр нь очиж танилцах буюу шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас авч болно.

7.3.Комиссын гишүүд нь сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн материалуудыг хянан үзээд энэ журамд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдийг дийлэнх олонхийн саналаар сонгож, санал дүгнэлтээ гаргана.

7.4.Комисс нь материал хүлээн авах хугацаа дууссан өдрөөс хойш ажлын 21 өдөрт багтаан сонгон шалгаруулалтыг хийж, санал дүгнэлтээ гаргана.

7.5.Комиссын санал, дүгнэлтийг Комиссын дарга хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

7.6.Комисс нь шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтад шалгарсан тухай харин бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг Комиссын санал, дүгнэлт гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор өгнө.

Найм.Тусгай зөвшөөрөл олгох

8.1.Шалгарсан хуулийн этгээд нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай^[2] хуулийн 13.1.1-д заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлж, баримтыг Комиссын нарийн бичгийн даргад өгнө.

8.2.Галт зэвсгийн тухай хуулийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Комиссын санал, дүгнэлтийг үндэслэн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрлийг олгоно.

8.3.Тусгай зөвшөөрөлд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай^[3] хуулийн 4.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.

Ес.Бусад зүйл

9.1.Оролцогч нь Комиссын санал, дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдлоо ажлын долоон өдрийн дотор хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргаж болно.

9.2.Гомдлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүлээн авснаас хойш ажлын арван өдөрт шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

9.3.Гомдол гаргасан хуулийн этгээд энэ журмын 9.2-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

----oOo----

^[1] Галт зэвсгийн тухай-“Төрийн мэдээлэл”-ийн 2015 оны № 31 дугаарт нийтлэгдсэн.

^[2] Улсын тэмдэгтийн хураамжийн тухай- “Төрийн мэдээлэл”-ийн 2011 оны № 1 дугаарт нийтлэгдсэн.

^[3] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай- “Төрийн мэдээлэл”-ийн 2001 оны № 6 дугаарт нийтлэгдсэн.

**ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ, ГАЛТ ЗЭВСЭГТЭЙ АДИЛТГАХ ХЭРЭГСЭЛ
ХУДАЛДАХ ТӨВД ЭРХ ОЛГОХ, САЛБАР НЭЭХ БОЛОН
ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдах төв /цаашид “Төв” гэх/ ажиллуулах эрх олгох, орон нутагт салбар нээх, Төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төв ажиллуулах эрхийг улсын хэмжээнд гурваас илүүгүй хуулийн этгээдэд нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.

1.3.Галт зэвсгийн тухай хуулийн 16.3 дахь хэсэгт заасан комисс сонгон шалгаруулалтыг эрхлэн гүйцэтгэнэ.

1.4.Комиссын бүрэлдэхүүн, үйл ажиллагааг Комиссын ажиллах журмаар зохицуулна.

1.5.Төвийн сонгон шалгаруулалт зарлах, сонгон шалгаруулалтын санал ирүүлэх, хүлээн авах, Комиссын санал, дүгнэлтэд гомдол гаргахтай холбоотой харилцааг “Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 3, 6, 9-д заасны дагуу зохицуулна.

Хоёр.Төв ажиллуулах хуулийн этгээдэд тавих шаардлага

2.1. Төв ажиллуулах хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.өөрийн ажлын байр болон агуулахтай байх;

2.1.2.Галт зэвсгийн тухай хуулийн 11.9 дэх хэсэгт заасны дагуу спортын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн баталсан шаардлагад нийцсэн буудлага үйлдэх байгууламж /тир/-тай байх;

2.1.3. галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл тээвэрлэх тусгайлан тоноглогсон буюу бүхээгтэй, цоожтой, аюултай ачааны таних тэмдэгтэй, галд тэсвэртэй материалаар тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй байх;

2.1.4.гадаадын хөрөнгө оруулалтгүй байх;

2.1.5.гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

2.1.6.хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй, гааль, татвар, нийгмийн даатгалын байгууллагад болон *шүүхийн шийдвэрийн дагуу иргэн, хуулийн этгээдэд төлөх өр төлбөргүй* байх.

2.2.Энэ журмын 2.1.1-д заасан ажлын байр, агуулах нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.аюулгүй байдлыг хангасан хамгаалалтын болон галын дохиоллын систем, гал унтраагч төхөөрөмж, хяналтын телекамераар тоноглогдсон байх;

2.2.2.харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр хамгаалуулах;

2.2.3.телехяналтын систем нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн баталсан “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага”-ыг хангасан байх;

2.2.4.байр, агуулахын хаалга нь төмөр, дотор тал нь галд шатдаггүй материалаар хийгдсэн, давхар хаалга, лацтай байх;

2.2.5.агуулах нь нарны гэрэл шууд тусахгүй, ус чийгнээс хамгаалагдсан, агааржуулалтын системтэй эсхүл салхивчтай байх. Салхивчтай бол дотор, гадна талаасаа төмөр хийцийн тороор хамгаалагдсан байна.

2.2.6.агуулахын галт хэрэгслийн тавиур нь хананаас 40 см-ээс багагүй зайд шалнаас 20 см-ээс багагүй өндөрт байх.

Гурав.Төв ажиллуулах сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг

3.1.Сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ:

3.1.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.2.үүсгэн байгуулсанаас хойш явуулж буй үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулга;

3.1.3.банк, татвар, гааль, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа, тодорхойлолт;

3.1.4.эрх бүхий аудитын байгууллагаар баталгаажсан сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан, баланс;

3.1.5.энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан барилга, байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.6.ажлын байр, агуулах, буудлага үйлдэх байгууламж /тир/-ийн байршил, дотоод зохион байгуулалт, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хадгалах шүүгээ /сав/, тавиурны нарийвчилсан зураг, танилцуулга, бусад бичиг баримт;

3.1.7.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгслийн холбогдох баримт бичгийн хуулбар;

3.1.8.харуул хамгаалалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний хуулбар;

3.1.9.энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг хангаж байгааг нотлох бусад баримт бичиг.

Дөрөв. Сонгон шалгаруулалт явуулах, Төв ажиллуулах эрх олгох

4.1.Комиссын гишүүд нь Төвийн сонгон шалгаруулалтад оролцогч тус бүр энэ журмын 2, 3-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, баримт бичгийг бүрэн гүйцэд зохих журмын дагуу бүрдүүлсэн эсэхийг хянан үзнэ.

4.2.Сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг хянах, шалгаруулахдаа “Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 7.2-7.6-д заасныг баримтлана.

4.3.Галт зэвсгийн тухай хуулийн 16.6 дахь хэсэгт заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Комиссын санал, дүгнэлтийг үндэслэн төв ажиллуулах эрхийг олгоно.

4.4.Төв ажиллуулах эрхийг Галт зэвсгийн тухай хуулийн 16.1 дэх хэсэгт заасан хугацаагаар олгоно.

Тав.Төвийн салбар нээх

5.1.Төв ажиллуулах эрхтэй хуулийн этгээд нь Галт зэвсгийн тухай хуулийн 16.7 дахь хэсэгт заасны дагуу орон нутагт салбартай байж болно.

5.2.Төвийн салбар нь үйл ажиллагаа явуулах газар /орон нутагт/-таа энэ журмын 2.1.1-д заасан байр, агуулах, буудлага үйлдэх байгууламж /тир/-тай байна.

5.3.Төв ажиллуулах эрхтэй хуулийн этгээд нь салбар нээх хүсэлтийг Комисст гаргах бөгөөд дор дурдсан баримтыг бүрдүүлж хандана:

5.3.1.үйл ажиллагаа явуулах байр, агуулах, буудлага үйлдэх байгууламж /тир/-ийн байршил, дотоод зохион байгуулалт, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хадгалах шүүгээ /сав/, тавиурны нарийвчилсан зураг, танилцуулга;

5.3.2.салбарын үйл ажиллагаа явуулах байр, агуулах, буудлага үйлдэх байгууламж /тир/ нь Галт зэвсгийн тухай хуулийн 14.5, энэ журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар тагнуул, цагдаа, мэргэжлийн хяналт, холбогдох бусад байгууллагын тодорхойлолт.

5.4.Комисс нь Төвийн салбар ажиллуулах байр, агуулах, буудлага үйлдэх байгууламж /тир/ аюулгүй байдлын болон бусад стандарт, дүрэм, журамд нийцэж байгаа эсэх талаар лавлагаа, мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас авч болно.

5.5.Комисс нь салбар нээх тухай хуулийн этгээдийн хүсэлтийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах ба Комиссын санал, дүгнэлтийг үндэслэн Төвийн салбар нээх зөвшөөрөл олгох эсэхийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

5.6.Комисс нь Төвийн салбар нээх хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар бичгээр хариу өгнө.

5.7.Төвийн салбар нээх зөвшөөрлийг Төв ажиллуулах эрхийн хугацаатай ижил хугацаагаар олгоно.

Зургаа.Төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах

6.1.Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд /цаашид “борлуулагч” гэх/ нь Галт зэвсгийн тухай хуулийн 16.7 дахь хэсэгт заасны дагуу Төвд байрлан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл худалдан борлуулна.

6.2.Төв ажиллуулах эрхтэй хуулийн этгээд болон борлуулагч нь Төвийн зохион байгуулалт, аюулгүй байдлын талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.2.1.Төв, агуулах, буудлага үйлдэх байгууламж /тир/-д ажиллах аюулгүй ажиллагааны дотоод журамтай байна.

6.2.2.Үйл ажиллагааны эрсдэл болон галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлтэй харьцаж ажиллах ажилтнуудын амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулсан байна.

6.2.3.Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлтэй харьцаж ажиллах ажилтнууд нь Галт зэвсгийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан насанд хүрсэн, сургалтад хамрагдсан, ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

6.2.4.Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг харуул хамгаалалтын алба хаагчаар хамгаалуулж, зориулалтын, аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

6.2.5.Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хадгалах агуулахын гадна буюу эргэн тойронд тэсэрч дэлбэрэх, галд шатамхай аюултай бодисыг байрлуулахгүй.

6.2.6.Болзошгүй аюул, гамшиг, халдлага бий болсон нөхцөлд ажиллах төлөвлөгөөтэй байна.

6.2.7.Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг тухай бүрт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэдэгдэж, цагдаагийн байгууллагын эргүүлийн чиглэл, хяналт-шалгалт хийх боломжоор хангана.

6.3.Төв ажиллуулах эрхтэй хуулийн этгээд энэ журмын 6.2-т зааснаас гадна дараах шаардлагыг хангаж ажиллана:

6.3.1.нэг борлуулагчид ногдох худалдааны талбайг 12 м², агуулахын талбайг 9 м²-аас тус тус багагүй хэмжээтэй байлгана.

6.3.2.Төв нь өөрийн агуулахыг Төвд байрлаж буй борлуулагч бүрийн тоогоор тусгаарлаж, борлуулагчийн агуулахын өрөө /тасалгаа/-нд бусад этгээд нэвтрэх боломжгүй байхаар зохион байгуулна.

6.3.3.Төвийн ажлын байр, агуулах, буудлага үйлдэх байгууламжийн аюулгүй байдлыг энэ журмын 2.2-т заасан шаардлага, аюулгүй ажиллагааны дотоод журамд нийцүүлэн ажиллана.

6.3.4.Төвийн хамгаалалт, дохиолол, телехяналтын системийг гэрээт харуул хамгаалалтын албаны байнгын хяналтад байлгана.

6.4.Борлуулагч нь дараах байдлаар аюулгүй байдлыг хангаж ажиллана:

6.4.1.Төвийн ажлын байранд борлуулж буй бүх галт зэвсгийн гохыг цоожилж аюулгүй байдлыг хангасан байна.

6.4.2.Галт зэвсгийн сумыг галт зэвсэгтэй хамт үйлчлүүлэгчид үзүүлэх, гохны цоожгүй галт зэвсэг үзүүлэхийг хориглоно.

6.4.3.Камерын бичлэг ажиллахгүй үед галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн худалдаа хийхгүй байна.

6.4.4.Худалдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн дэлгэрэнгүй бүртгэлийг Галт зэвсгийн тухай хуулийн 17.6 дахь хэсэгт заасан загварын дагуу хөтөлнө.

6.4.5.Агуулахад галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг сумнаас тусад нь дараах байдлаар хадгална:

а/галт зэвсэг /урт буу/, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг тусгай бэлтгэсэн давхар тавиур дээр нэг эгнээнд тоолж болохуйц 10-20 ширхэгээр эгнүүлэн байрлуулна.

б/гар бууг аюулгүй байдлыг хангасан саванд гохыг түгжиж хадгална.

в/сумыг тусгайлан савалсан хайрцагт, шаардлага хангасан өрөөнд төмөр шүүгээнд хадгална.

6.4.6.Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн агуулах, өрөөний түлхүүрийг хариуцсан ажилтан төмөр хайрцагт хийж, лацдан харуул хамгаалалтын ажилтанд хадгалуулна. Харуул хамгаалалтын ажилтан нь агуулахын лац хүлээн авсан, хүлээлгэн өгсөн бүртгэлийн дэвтрийг өдөр тутам хөтөлнө.

6.4.7.Алдагдсан, дутсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн талаар тагнуул, цагдаагийн байгууллагад мэдсэн даруйдаа мэдэгдэнэ.

6.4.8.Борлуулагч нь Галт зэвсгийн тухай хуулийн 16.8 дахь хэсэгт заасан баримт бичгийг авч энэ хуулийн 17.4 дэх хэсэгт заасан хугацаанд цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

6.5.Төвд байрлан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдах ажилтныг борлуулагч нь өөрөө томилно.

6.6.Төвд байрлан галт зэвсэг, сум худалдахтай холбоотойгоор борлуулагч болон Төв ажиллуулах эрхтэй этгээдийн хооронд үүсэх энэ журмаар зохицуулаагүй харилцааг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

----oOo----